



УЛААНБААТАР ХОТЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН  
ТУШААЛ

2020 оны 01 сарын 24 өдөр

Дугаар ААР

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.2, 3 дугаар хэсгийн 3.1.10 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Нийслэлийн нутаг дэвсгэрт оршуулгын үйл ажиллагааг зохион байгуулах" журмын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд нийслэлийн нутаг дэвсгэрт зөвшөөрөлгүй оршуулсан шарилыг нүүлгэн шилжүүлэх, чандарлах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга	С.Аригуун	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хог хаягдлын удирдлага, зохицуулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Гишүүд	Т.Энх-Амгалан	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хог хаягдлын удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн
	Э.Уянга	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн
	Т.Мөнхнасан	Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 3-р хороо, 24-39 тоотод оршин суугч иргэн /Зөвшилцсөнөөр/
Нарийн бичгийн дарга	Б.Мөнхбаяр	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хог хаягдлын удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн

2. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж ажиллахыг Үнэлгээний хороо /С.Аригуун/-нд үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР  
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА Т.ГАНТӨМӨР



C:\Users\Gantuya\Desktop\ҮЖ 12\doc 2020\Тушаал 2doc.docx

• 1110300095